



ЦАГДААГИЙН ЕРӨНХИЙ ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ

2014 оны 02 сарын 27 өдөр

Дугаар 134

Улаанбаатар хот

Г Орон тооны бус зөвлөл байгуулах Т
тухай

Монгол Улсын Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4 дэх хэсгийг үндэслэн ТУШААХ нь:

1. Авлигын эсрэг хууль, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх хууль тогтоомжийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулж, хяналт тавих үүрэг бүхий орон тооны бус зөвлөлийг дор дурдсан бүрэлдэхүүнтэйгээр байгуулсугай.

Зөвлөлийн дарга:

- Цагдаагийн ерөнхий газрын дэд бөгөөд Дотоод хяналт-Аюулгүй байдлын газрын дарга

Нарийн бичгийн дарга:

- Дотоод хяналт-Аюулгүй байдлын газрын Хяналт- шалгалт, дотоод аудитын хэлтсийн дарга

Гишүүдэд:

- Гэмт хэрэгтэй тэмцэх газрын дарга
- Нийтийн хэв журам хамгаалах газрын дарга
- Олон нийтийн аюулгүй байдлыг хангах газрын дарга
- Санхүү, хангамжийн газрын дарга
- Нийслэлийн цагдаагийн газрын дарга
- Дотоод хяналт-Аюулгүй байдлын газрын Аюулгүй байдлыг хангах хэлтсийн дарга
- Хууль тогтоомжийн хэрэгжилт, дотоод ажлын хэлтсийн дарга
- Хүний нөөц, сургалтын хэлтсийн дарга
- Сургалт дадлагын төвийн дарга
- Хэвлэл, мэдээллийн төвийн дарга
- Лицензийн төвийн дарга

2. Энэ тушаал гарсантай холбогдуулан Цагдаагийн ерөнхий газрын даргын 2013 оны 22 дугаар тушаалыг хүчингүй болгосугай.

3. Зөвлөлийг удирдлага, зохион байгуулалтаар ханган ажиллаж, дүнг тооцож ажиллахыг зөвлөлийн дарга /цагдаагийн хурандаа Д.Эрдэнэбаатар/-д үүрэг болгосугай.

ДАРГА,
БРИГАДЫН ГЕНЕРАЛ

Б.БИЛЭГТ

ХУУЛБАР ҮНЭН
Хууль тогтоомжийн хэрэгжилт,
дотоод ажлын хэлтсийн дарга,
цагдаагийн дэд хурандаа



А.Даваасүрэн

0900989